**Нью Проспект Аудит**

Нягтлан бодох бүртгэл, аудит, татвар, зөвлөх үйлчилгээ

2016 оны 03 сарын 29 өдөр № 2/04 Улаанбаатар хот

**Хараат бус аудиторын дүгнэлт**

Чингис хаан банк ХХК - ийн
Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Бид Чингис хаан банк ХХК ("Банк")-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлого, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

*Санхүүгийн тайлангийн талаарх банкны удирдлагын хариуцлага*

Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), түүнд нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь банкны удирдлагын үүрэг, хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь энэхүү хариуцлагад хамаарна.

*Аудиторын хариуцлага*

Хийсэн аудитын ажилдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт гаргах нь бидний хариуцлага билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Энэхүү стандарт нь биднээс санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн талаарх зохистой нотолгоог олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг шаарддаг.

Санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын талаарх аудитын нотолгоог олж авахын тулд горимуудыг гүйцэтгэх нь мөн аудитын ажилд багтдаг. Горимын сонголт нь аудиторын мэргэжлийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах бөгөөд үүнд залилан буюу алдааны улмаас санхүүгийн тайланг материаллагаар буруу илэрхийлэх эрсдлийн үнэлгээ хамаарна. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах биш, харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг сонгох үүднээс банкны санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Мөн банкны удирдлагын хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, хийсэн тооцооллын үндэслэл болон санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явцад үнэлдэг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 3-р хороо, 12-р хороолол, Цэнд гуний гудамж-31, НИММ Проперти компанийн байр 203 тоот

Утас: +976 7000 0309
Вэбсайт: www.newprospect.mn

## Хараат бус аудиторын дүгнэлт, Үргэлжлэл

*Дүгнэлтийн үндэслэл*

Санхүүгийн тайлангийн тодруулга 3-д дурьдсанчлан банк 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлийн багцыг өөрийн бодлогоор үнэлж, эрсдлийн нөөц байгуулсан.

*Дүгнэлт*

Бидний дүгнэлтээр, дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурьдсанаас бусад зүйлсийн хувьд санхүүгийн тайлан нь Чингис хаан банк ХХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монголбанкнаас баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

*Бусад*

Банкны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангийн аудитыг БДО Аудит ХХК гүйцэтгэж, уг тайланд 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр аудиторын нэмэлт дүгнэлт бүхий зөрчилгүй дүгнэлт гаргасан болно. 2015 оны санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэх мэдээлэл нь уг зөрчилгүй дүгнэлт бүхий санхүүгийн тайланд үндэслэсэн.

NEW PROSPECT AUDIT LLC
НЬЮ ПРОСПЕКТ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

Нью Проспект Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2016 оны 3 дугаар сарын 29-ний өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2016 оны 3 дугаар сарын 29-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүй болохыг анхаарна уу.

ЧИНГИС ХААН БАНК
2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
**Санхүүгийн байдлын тайлан**

| *(Мянган төгрөгөөр)* | | 2015 | 2014 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө | 5 | 42,472,488 | 20,911,829 |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө | 6 | 11,820,158 | 39,040,575 |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө | 7 | 8,523,759 | 239,430 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгө | 8 | 759,151 | 21,077 |
| Зээл ба урьдчилгаа, цэвэр | 9 | 158,195,800 | 157,942,990 |
| Өмчлөх бусад хөрөнгө, цэвэр | 10 | 345,967 | 4,655,189 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 30 | - | 18,317 |
| Бусад хөрөнгө | 11 | 1,295,005 | 1,035,353 |
| Үндсэн хөрөнгө, цэвэр | 12 | 4,030,197 | 4,073,380 |
| Биет бус хөрөнгө, цэвэр | 13 | 194,593 | 199,944 |
| **Хөрөнгийн дүн** | | **227,637,118** | **228,138,084** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгө** | | | |
| **Өр төлбөр** | | | |
| Харилцагчдын харилцах | 14 | 38,856,402 | 46,568,663 |
| Харилцагчдын хадгаламж | 15 | 49,208,258 | 44,150,688 |
| Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр | 16 | 43,285,868 | 26,400,000 |
| Төслийн зээлийн эх үүсвэр | 17 | 66,398,907 | 78,983,410 |
| Бусад эх үүсвэр | 18 | 6,949,246 | 12,228,985 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 30 | 26,831 | - |
| Бусад өр төлбөр | 19 | 872,940 | 972,507 |
| **Өр төлбөрийн дүн** | | **205,598,452** | **209,304,253** |
| **Өөрийн хөрөнгө** | | | |
| Хувьцаат капитал | 20 | 39,373,246 | 39,373,246 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | | (17,334,580) | (20,539,415) |
| **Өөрийн хөрөнгийн дүн** | | **22,038,666** | **18,833,831** |
| **Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн** | | **227,637,118** | **228,138,084** |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ЧИНГИС ХААН БАНК
2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
**Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**

| *(Мянган төгрөгөөр)* | | 2015 | 2014 |
|---|---|---|---|
| Хүүний орлого | 21 | 22,964,240 | 19,666,070 |
| Хүүний зардал | 22 | (12,867,911) | (14,616,083) |
| **Хүүний цэвэр орлого** | | **10,096,329** | **5,049,987** |
| Арилжааны цэвэр олз (гарз) | 23 | 587,497 | 668,911 |
| Ханшийн тэгшитгэлийн цэвэр олз (гарз) | 24 | 451,480 | (183,170) |
| Шимтгэл, хураамжийн орлого | 25 | 1,343,015 | 1,053,219 |
| **Хүүний бус цэвэр орлого** | | **2,381,992** | **1,538,960** |
| **Үйл ажиллагааны орлого** | | **12,478,321** | **6,588,947** |
| Үйл ажиллагааны зардал | 26 | (7,693,684) | (7,532,275) |
| **Үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг (алдагдал)** | | **4,784,637** | **(943,328)** |
| Үнэ цэнийн бууралтын зардал, нөхөлт | 27 | (1,609,528) | (792,720) |
| **Үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | | **3,175,109** | **(1,736,048)** |
| Үйл ажиллагааны бус орлого | 28 | 200,533 | 206,552 |
| Үйл ажиллагааны бус зардал | 29 | (124,580) | (161,955) |
| **Орлогын татвараас өмнөх ашиг** | | **3,251,062** | **(1,691,451)** |
| Орлогын татварын (зардал) хөнгөлөлт | 30 | (46,226) | 67,236 |
| **Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)** | | **3,204,836** | **(1,624,215)** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| **Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс** | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн цэвэр өөрчлөлт | | - | - |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого** | | **3,204,836** | **(1,624,215)** |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ЧИНГИС ХААН БАНК
2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
**Өмчийн өөрчлөлтийн тайлан**

| *(Мянган төгрөгөөр)* | Тод | Хувьцаат капитал | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Өмчийн дүн |
|---|---|---|---|---|
| 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | | 39,373,246 | (18,915,200) | 20,458,046 |
| Тайлант жилийн цэвэр ашиг, алдагдал | | - | (1,624,215) | (1,624,215) |
| Нэмж гаргасан хувьцаа | | - | - | - |
| **2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр** | 20 | **39,373,246** | **(20,539,415)** | **18,833,831** |
| 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр | | 39,373,246 | (20,539,415) | 18,833,831 |
| Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал) | | - | 3,204,836 | 3,204,836 |
| Хуваарилсан ногдол ашиг | | - | - | - |
| Нэмж гаргасан хувьцаа | | - | - | - |
| **2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр** | 20 | **39,373,246** | **(17,334,580)** | **22,038,666** |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*

ЧИНГИС ХААН БАНК
2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
**Мөнгөн гүйлгээний тайлан**

| *(Мянган төгрөгөөр)* | 2015 | 2014 |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | |
| **Тайлант жилийн цэвэр (алдагдал)/ ашиг** | **3,251,061** | **(1,691,451)** |
| Тохируулга: | | |
| Элэгдэл ба хорогдуулга | 452,421 | 475,048 |
| Болзошгүй эрсдлийн зардал ба нөхөлт | 1,609,528 | 792,720 |
| Хүүний орлого | (22,964,240) | (19,666,070) |
| Хүүний зардал | 12,867,911 | 14,616,082 |
| Үндсэн хөрөнгө худалдсны (олз) гарз | (4,181) | (4,604) |
| **Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал):** | **(4,787,500)** | **(5,478,273)** |
| Үйл ажиллагааны хөрөнгийн (өсөлт) бууралт: | | |
| Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө | 27,220,416 | (15,215,305) |
| Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө | (8,730,872) | - |
| Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа санхүүгийн хөрөнгө | (738,074) | 118,158 |
| Зээлийн багцын цэвэр (өсөлт) бууралт | 2,635,379 | (40,285,257) |
| Өмчлөх бусад хөрөнгө | 8,618,445 | - |
| Бусад хөрөнгө | 264,559 | 1,734,149 |
| Үйл ажиллагааны өр төлбөрийн өсөлт, (бууралт) | | |
| Харилцах, хадгаламж | (2,654,690) | 14,260,657 |
| Бусад банкнаас татсан эх үүсвэр | 16,885,868 | (10,214,963) |
| Төслийн зээлийн эх үүсвэр | (12,584,503) | 8,798,246 |
| Бусад эх үүсвэр | (5,279,740) | 1,615,695 |
| Бусад өр төлбөр | 23,310 | 150,968 |
| Хүлээн авсан хүү | 14,438,548 | 22,891,141 |
| Төлсөн хүү | (12,990,789) | (14,512,397) |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | **22,320,359** | **(36,137,180)** |
| Орлогын татварын төлөлт | (1,078) | (141,992) |
| Эрсдлийн сангаас хаасан зээл, авлага | (366,543) | (8,475) |
| Эрсдлийн сангийн бусад өөрчлөлт | 7,627 | 104,031 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **21,960,365** | **(36,183,616)** |
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ:** | | |
| Худалдаж авсан үндсэн хөрөнгө | (383,147) | (236,326) |
| Худалдаж авсан биет бус хөрөнгө | (25,365) | (83,633) |
| Худалдсан үндсэн хөрөнгө | 8,806 | 22,710 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(399,706)** | **(297,249)** |

**Мөнгөн гүйлгээний тайлан**

| *(Мянган төгрөгөөр)* | 2015 | 2014 |
|---|---|---|
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | |
| Нэмж гаргасан хувьцаа | - | - |
| Санхүүгийн зах зээлээс авсан (төлсөн) мөнгө | - | - |
| Хоёрдогч өглөгийн өсөлт (бууралт) | - | - |
| Халаасласан хувьцаа | - | - |
| Хуваарилсан ногдол ашиг | - | - |
| Өмчийн бусад өөрчлөлт | - | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | - | - |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **21,560,659** | **(36,480,865)** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 20,911,829 | 57,392,694 |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **42,472,488** | **20,911,829** |

*Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.*